



Харилцаа холбооны зохицуулах хорооны  
2017 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн  
34 тоот тогтоолын  
хавсралт

Үүрэн телефон холбооны үйлчилгээний зах зээлд давамгайлагч үйлчилгээ эрхлэгчийн  
“Үүрэн холбооны багцын үйлчилгээний тодорхойлолт,  
багцын үйлчилгээний үнэ тариф”

1. Үүрэн холбооны яриа, мессэж, дата болон бусад нэмэлт үйлчилгээг тодорхой үнийн дүнд багтаан 2 /хоёр/ болон түүнээс дээш хэмжээний бүтээгдхүүний орцтой, тодорхой хугацаанд ашиглах боломжтой байдлаар багцлан худалдаалж буй дараа төлбөрт болон урьдчилсан төлбөрт үйлчилгээний нөхцөл, цэнэглэгч картуудыг “үүрэн холбооны багц үйлчилгээ” гэнэ.
  - 1.1. Цэнэглэгч картаар багцын хугацааг сунгаж болох бөгөөд сунгасан тохиолдолд хэрэглэгчийн нийт төлөх дүн нь уг багцыг 1 /нэг/ сараар сунгахад төлөх дүнгээс багагүй байна.
  - 1.2. Үүрэн холбооноос бусад үйлчилгээг үүрэн холбооны багц үйлчилгээний хөнгөлөлтөнд оруулан тооцохгүй.
  - 1.3. Багцын хэрэглэгчид гар утас лизингээр худалдаалж байгаа тохиолдолд гар утасны үнийг өртгөөс доош оруулахгүй бөгөөд багцын үнээс ямар нэгэн хөнгөлөлт олгохгүй.
2. Хэрэв багцад сүлжээндээ хязгааргүй ярих эрх орсон бол доод үнийн хязгаар тогтооно.
  - 2.1. Үүрэн холбооны давамгай байдалтай үйлчилгээ эрхлэгчийн сүлжээндээ хязгааргүй ярих үйлчилгээний доод үнийн хязгаар 9000 төгрөг байна /НӨАТ ороогүй дүн/.
3. Багц дотор бусад сүлжээнд ярих 1 /нэг/ минутын доод хязгаарыг тогтооно.
  - 3.1. Багц дотор бусад сүлжээнд ярих 1 /нэг/ минутын төлбөрийн доод хэмжээ нь харилцан холболтын төлбөрийг 2 /хоёр/ дахин нэмэгдүүлсэн хэмжээнээс багагүй байна.
4. Үүрэн холбооны багцын орцод ороогүй ярианы үйлчилгээний тарифыг стандарт тариф гэж үзнэ.
5. Үүрэн холбооны багцын орцод орсон үүрэн холбооны ярианаас бусад бүтээгдэхүүн, үйлчилгээний тарифыг тухайн бүтээгдхүүний өртгөөс багагүй байхаар тооцно.

----- оОо -----